

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан арга хэмжээний биелэлтэд 2016 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан.

2017 оны 01 дүгээр сарын 30

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 36 зорилтын 105 арга хэмжээг хяналтанд авч сайдын 2017 оны А/22 дугаар тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан 105 арга хэмжээ, үүнээс үндсэн хэрэгжүүлэгчээр 76, хамтран хэрэгжүүлэх 28, оролцогчоор хэрэгжүүлэх 1 арга хэмжээний биелэлтэд 2016 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Яамны 2016 онд хэрэгжүүлсэн нийт 105 арга хэмжээнээс дангаар хэрэгжүүлсэн 76 арга хэмжээний биелэлт 23.0%, хамтран хэрэгжүүлсэн 28 арга хэмжээний биелэлт 18,3%, нийт арга хэмжээ 22,4%-ийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО
/2016 жилийн эцэс, зорилт, арга хэмжээгээр/**

Зорилт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо							Хэрэгжилт /хувь/
			100	90	70	50	30	10	/-/	
Нэг. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого	4	6					1	4	1	14.0
Хоёр. Эдийн засгийн тогвортой есөлтийг хангах бодлого	25	85	3	2	1	6	14	47	12	23.8
Гурав. Нийгмийн бодлого	2	3						1	2	10.0
Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	5	11						4	7	10.0
Дүн	36	105	3	2	1	6	15	56	22	22.4

“Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэрэгжүүлсэн зорилт, арга хэмжээний биелэлтийг үзүүлбэл:

- 100 хувийн биелэлттэй:

- 2.68.1. “Алт-2” хөтөлбөрийн санхүүжилтийн тооцоог гаргах,
 - 2.69.1. “Алт-2” хөтөлбөрийг боловсруулан батлуулах
 - 2.72.2. Давтах аргаар ган бөмбөлөг үйлдвэрлэх цехийг ашиглалтад оруулах,
 - 2.73.1. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийн нэгж байгуулах
- 90 хувийн биелэлттэй:
 - 2.69.6. *Ашиглалтад оруулахад бэлэн болсон алтны уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэхбичих*
- 70 хувийн биелэлттэй:
 - 2.17.4 *Улсын болон компанийн нөөцийг бүрдүүлэх*
- Биелэлтэд үнэлгээ хийгээгүй:
 - Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас холбогдох санал ирүүлээгүйтэй холбоотойгоор 22 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ хийгээгүй болно.

ДҮГНЭЛТ:

Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөн, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө оройтож батлагдсан зэрэг хүчин зүйлээс шалтгаалан төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хяналтанд авах, хэрэгжилт гаргах, түүнд явцын үнэлгээ хийх хугацаа бага байв.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн эхний үнэлгээгээр нийт дундаж 22,4%-тай байгаа ч зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр цаашид хэрэгжилт өснө гэж үзлээ.

САНАЛ ЗӨВЛӨМЖ:

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, үнэлгээний тайлангийн хамт Сайдаас ЗГ-ын ХЭГ-т хүргүүлдэг тул яамны нэгжүүд гаргаж буй биелэлтийн утга найруулга, агуулгыг сайтар анхаарч байх шаардлагатай байна. Жилийн эцсийн байдлаар ирүүлсэн биелэлтэд утга найруулга алдаатай, тавьсан зорилтдоо хамааралгүй биелэлт гаргаж энэ нь буцаагдах зэргээр хугацаа алдах нөхцлийг бүрдүүлж байгааг газар, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнүүд цаашид анхаарч ажиллах.

2. 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар нийт 28 арга хэмжээг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан /үндсэн хэрэгжүүлэгч нь ТӨБЗГ, ЗГХЭГ, СХЗГ, Монголбанк, БХБЯ, ХНХЯ-тай хамтран тус бүр 1, ЭХЯ, ЦЭКАА-тай хамтран тус бүр 2, ХХААХҮЯ-тай 3, СЯ-тай 4, БОАЖЯ-тай 11 арга хэмжээ/. Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад бэрхшээлтэй, тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас ханддаггүй бэрхшээл үүсдэг. Иймд яамны

зүгээс эдгээр байгууллагатай хамтран ажиллах талаар өөрийн идэвхи санаачлага гаргаж ажиллах нь зүйтэй байна.

ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан нэгтгэлийг хавсаргав.

Хянасан:

ХШҮДАГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч

Ц.Одхүү

Үнэлгээ хийж тайлан боловсруулсан:

Ахлах мэргэжилтэн

Б.Баяржаргал

Мэргэжилтэн

Д.Батнайрамдал

Н.Цогтбаяр